

Ангилал

Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр

Тогтвортой хөгжлийн зорилготой нийцэж буй байдал

1. Сэргээгдэх эрчим хүч

Сүлжээнд холбогдсон болон бие даасан сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, суурилуулалт

- Салхины эрчим хүч
- Нарны эрчим хүч - нарны панель (PV) болон төвлөрсөн нарны эрчим хүч (CSP)-ний байгууламжууд
- Бага оврын усан цахилгаан станц (25МВт-аас ихгүй хүчин чадалтай, ус нөөцлүүр болон шахаж хадгалах зориулалтай)

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах



2. Бохирдол багатай эрчим хүч үйлдвэрлэл

Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх байгууламжийн барилга, угсралт, засвар, үйлдвэрлэл

- Ахуйн хог хаягдлаас эрчим хүчийг үйлдвэрлэх байгууламж

Хүлэмжийн хий ялгарал, бохирдол багатай эрчим хүч үйлдвэрлэл

- Байгалийн хий, био түлш болон хүлэмжийн хийн ялагарал бага бусад төрлийн түлшний үйлдвэрлэл, тээвэрлэлт, түгээлт, эрчим хүчний үйлдвэрлэл
- Эрчим хүч, дулаан үйлдвэрлэх өндөр үр ашиг бүхий зуух, бойлер

Бохирдлоос урьдчилан сэргийлэх

Хог хаягдлыг бууруулах

2.5 тоосонцор (PM2.5)-ыг бууруулах

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах



3. Эрчим хүчний хэмнэлт

- Эрчим хүчний хэмнэлттэй технологи, тоног төхөөрөмж
- Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга, байгууламжийн угсралт болон хуучин барилгын засвар, шинэчлэлт ба сайжруулалт (дулаалга, гэрэлтүүлэг зэрэг)
- Эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн бараа, бүтээгдэхүүн

Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх

Эрчим хүчний хэрэглээг бууруулах

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах



4. Ногоон барилга

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон барилгын гэрчилгээ авсан барилга, байгууламж:

- Шинэ барилга, байгууламжийн угсралт
- Хуучин барилгын засвар, шинэчлэлт ба сайжруулалт

Тогтвортой хотыг бий болгох

Ногоон барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах



5. Тогтвортой ус ба хог хаягдал

Усны тогтвортой менежмент:

- Цас борооны ус хуримтлуулах байгууламж
- Усны хэрэглээг бууруулах технологи, практик нэвтрүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах
- Хаягдал усыг боловсруулах болон саарал усыг дахин ашиглах

Хатуу хог хаягдлын тогтвортой менежмент:

- Хог хаягдлыг цуглуулах, ангилах, дахин боловсруулах эсвэл дахин ашиглах

Ус болон бохир усны тогтвортой менежмент

Усны хэрэглээг бууруулах

Бохирдлоос урьдчилан сэргийлэх

Хогийн цэг дээр хаягдах хог хаягдлыг багасгах



6. Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой ба биологийн төрөл зүйл

Тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэл:

- Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах
- Малын өтөг, бууцны менежментийг сайжруулах
- Зохистой мал маллагаа, сүргийн менежмент, малын чанарыг сайжруулах, тоо толгойг бууруулах практик нэвтрүүлэх

Тогтвортой газар тариалангийн үйлдвэрлэл:

- Азотын бордооны хэрэглээг бууруулах, зохистой бордооны менежмент
- Хөрс хамгаалах практик, технологи нэвтрүүлэх
- Органик үйлдвэрлэл
- Усны хэмнэлттэй усалгааны систем суурилуулах
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, өндөр үр ашиг бүхий үр, үр тарианы хэрэглээг нэмэгдүүлэх

Тогтвортой ойн менежментийг сайжруулах, мод тариалалт

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

Ган гачигт болон хортон шавьжид тэсвэртэй үр, тарианы хэрэглээг нэмэгдүүлэх

Тогтвортой хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих

Азотын бордооны хэрэглээг багасгах;
Усны менежментийг сайжруулах;
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

Байгалийн нөөцийг хамгаалах

Нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх



7. Цэвэр тээвэр

- Хүлэмжийн хийн шууд ялгарал тэг буюу цахилгаан тээврийн хэрэгслийн худалдан авалт, нийлүүлэлт
- Хүлэмжийн хийн ялгарал багатай буюу хос хөдөлгүүрт, байгалийн хийн болон түлшний хэмнэлттэй тээврийн хэрэгслийн худалдан авалт, нийлүүлэлт
- Цахилгаан болон байгалийн хийн цэнэглэх станцуудын барилга, угсралт
- Мэдээлэл, харилцааны технологийн шийдэлд суурилсан тээврийн хэрэгслийн ашиглалт, горимын шилжилтийн сайжруулалт

Бохирдлоос урьдчилан сэргийлэх

Агаарын бохирдлыг бууруулах

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах

